



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай хот
2024 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-undraaD@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: BaasanjargalG@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЯРУУ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ДАРИЙМАА-Д

2024.02.19 № 52

танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Яруу сумын Засаг даргын Тамгын газраас тайлант онд Тамгын газрын дарга, Санхүүгийн албаны дарга нар өндөр насны тэтгэвэрт гарч ажлын сул орон тоог зарласан байна. Үүнтэй холбоотойгоор тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 46,611,600 төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс морин уралдааны телевизийн бичлэг хийлгэн 1,000,000 төгрөгийн зориулалт бус, үр ашиггүй зардал гаргасан. Мөн иргэн, байгууллагуудад дэмжлэг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу, хяналтыг дутуу хэрэгжүүлсэн зэрэг зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдсэн 33,918,000 төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг, 18,277,000 төгрөгийн сэлбэг хэрэгсэл, аж ахуйн материалыг данс бүртгэлд тусгаагүй алдааг тус тус залруулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,101,353.29	8,734,472.00
33	АВЛАГА	12,601.29	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,601.29	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,088,752.00	8,734,472.00
35400	Хангамжийн материал	14,088,752.00	8,734,472.00
35410	Бичиг хэргийн материал	696,000.00	723,000.00
35420	Аж ахуйн материал	6,282,752.00	2,076,152.00
35440	Түлш, шатах тослох материал	5,000,000.00	269,080.00
35450	Барилгын засварын материал	1,500,000.00	1,500,000.00
35470	Бусад хангамжийн материал	610,000.00	4,166,240.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	395,516,982.24	405,682,889.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	395,516,982.24	405,682,889.94
39200	Биет хөрөнгө	388,421,482.24	394,679,889.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	439,719,675.50	454,719,675.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-149,327,713.42	-
			165,838,729.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,200,000.00	108,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-82,530,000.42	-86,756,666.98
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	201,450,516.00	201,450,516.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-150,614,847.96	-
			165,650,763.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,630,178.56	39,630,178.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,567,437.45	-31,716,890.11
39212	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.00	0.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,234,579.00	65,152,579.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,773,467.57	-24,510,009.21
39300	Биет бус хөрөнгө	7,095,500.00	11,003,000.00
39301	Програм хангамж	2,802,000.00	7,302,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,004,500.00	-2,597,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,298,000.00	6,298,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	409,618,335.53	414,417,361.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	143.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	143.30
41300	Өглөг	0.00	143.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	143.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	409,618,335.53	414,417,218.64
51	Засгийн газрын хувь оролцоо	409,618,335.53	414,417,218.64
51100	Засгийн газрын оруулсан капитал	312,259,773.46	312,259,773.46
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	312,259,773.46	312,259,773.46
51200	Хуримтлагдсан үр дүн	-35,391,629.84	-30,592,746.73
51210	Өмнөх үеийн үр дүн	-46,156,576.37	-35,391,629.84
51220	Тайлант үеийн үр дүн	10,764,946.53	4,798,883.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	132,750,191.91	132,750,191.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	409,618,335.53	414,417,361.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	405,722,999.00	93,849,545.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,300,000.00	53,324,440.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,300,000.00	53,324,440.00
120009	Бусад орлого	0.00	850,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,300,000.00	48,918,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	3,556,240.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,422,999.00	40,525,105.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,935,000.00	40,525,105.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,935,000.00	40,525,105.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	373,487,999.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	373,487,999.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	394,958,052.47	623,094,905.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,958,052.47	623,094,905.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,321,534.60	576,483,305.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,482,360.39	329,831,997.45
210101	Үндсэн цалин	192,346,341.79	221,422,191.24
210102	Нэмэгдэл	17,422,449.00	91,569,339.06
210104	Урамшуулал	3,713,569.60	16,840,467.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,309,230.79	40,998,485.77
210201	Тэтгэврийн даатгал	18,299,458.28	28,617,389.12
210202	Тэтгэмжийн даатгал	2,152,879.91	3,315,929.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,722,299.69	2,613,141.52
210204	Ажилгүйдлийн даатгал	375,869.84	586,546.76
210205	Эрүүл мэндийн даатгал	3,758,723.07	5,865,478.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,774,902.66	25,191,953.72
210301	Гэрэл, цахилгаан	1,119,366.66	1,568,953.72
210302	Түлш, халаалт	28,655,536.00	23,623,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,269,238.00	51,551,275.00
210401	Бичиг хэрэг	4,013,200.00	4,082,600.00
210402	Тээвэр, шатахуун	21,595,000.00	37,454,225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,775,200.00	2,678,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,885,838.00	7,336,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,553,250.00	182,300.00
210604	Урсгал засвар	6,553,250.00	182,300.00

2107	Томилолт, зочны зардал	1,592,800.00	7,406,300.00
210702	Дотоод албан томилолт	1,592,800.00	7,406,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,991,049.00	2,061,641.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,085,800.00	1,654,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	373,475.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	50,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,674.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	200,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	74,992.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,636,517.87	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,636,517.87	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,764,946.53	-529,245,360.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

<i>/ төгрөгөөр /</i>			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	402,422,999.00	41,375,305.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	850,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	850,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	375,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	375,000.00
120009	Бусад орлого	0.00	475,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,422,999.00	40,525,105.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,935,000.00	40,525,105.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,935,000.00	40,525,105.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	373,487,999.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	373,487,999.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,844,699.00	570,919,548.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,844,699.00	570,919,548.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	364,208,181.13	524,307,948.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,992,465.47	329,819,330.16
210101	Үндсэн цалин	167,916,021.87	221,409,523.95
210102	Нэмэгдэл	37,685,429.00	91,569,339.06
210104	Урамшуулал	7,391,014.60	16,840,467.15

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,735,676.00	40,998,408.47
210201	Тэтгэврийн даатгал	18,210,200.00	28,617,367.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,139,309.17	3,315,837.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,707,244.93	2,613,177.32
210204	Ажилгүйдлийн даатгал	416,277.60	586,546.76
210205	Эрүүл мэндийн даатгал	4,262,644.30	5,865,478.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,774,902.66	25,191,953.72
210301	Гэрэл, цахилгаан	1,119,366.66	1,568,953.72
210302	Түлш, халаалт	28,655,536.00	23,623,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,193,900.00	37,040,617.00
210401	Бичиг хэрэг	1,254,700.00	3,696,100.00
210402	Тээвэр, шатахуун	23,094,500.00	30,611,517.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,844,700.00	2,733,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,541,850.00	6,235,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	225,000.00	0.00
210604	Урсгал засвар	13,316,850.00	6,235,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,592,800.00	7,406,300.00
210702	Дотоод албан томилолт	1,592,800.00	7,406,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,991,049.00	2,661,641.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,085,800.00	2,254,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	373,475.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	50,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,674.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	200,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	74,992.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,385,538.00	74,953,898.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,082,138.00	74,650,498.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,636,517.87	46,611,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	46,611,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	46,611,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,636,517.87	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,636,517.87	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	31,578,300.00	-529,544,243.35
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	31,578,300.00	4,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,578,300.00	4,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,578,300.00	4,500,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,578,300.00	4,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-31,578,300.00	-4,500,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	-534,044,243.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-46,156,574.51	398,853,390.86
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-35,391,629.84	409,618,335.53
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-46,156,576.37	398,853,389.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-1.86	-1.86
9	Тайлант үеийн үр дүн	0	0	10,764,946.53	10,764,946.53
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-35,391,629.84	409,618,335.53
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-30,592,746.73	414,417,218.64
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	312,259,773.46	132,750,191.91	-35,391,629.84	409,618,335.53
19	Тайлант үеийн үр дүн	0	0	4,798,883.11	4,798,883.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	554,589,800.00	534,894,443.35	534,894,443.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	554,589,800.00	534,894,443.35	534,894,443.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,978,200.00	488,282,843.35	488,282,843.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	343,976,800.00	329,819,330.16	329,819,330.16
210101	Үндсэн цалин	244,738,900.00	221,409,523.95	221,409,523.95
210102	Нэмэгдэл	99,237,900.00	91,569,339.06	91,569,339.06
210104	Урамшуулал	0	16,840,467.15	16,840,467.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,997,200.00	40,998,408.47	40,998,408.47
210201	Тэтгэврийн даатгал	29,238,000.00	28,617,367.76	28,617,367.76
210202	Тэтгэмжийн даатгал	3,439,800.00	3,315,837.72	3,315,837.72

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,751,800.00	2,613,177.32	2,613,177.32
210204	Ажилгүйдлийн даатгал	688,000.00	586,546.76	586,546.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6,879,600.00	5,865,478.91	5,865,478.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,312,100.00	25,191,953.72	25,191,953.72
210301	Гэрэл, цахилгаан	1,689,100.00	1,568,953.72	1,568,953.72
210302	Түлш, халаалт	23,623,000.00	23,623,000.00	23,623,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,616,500.00	29,337,430.00	29,337,430.00
210401	Бичиг хэрэг	3,609,600.00	3,601,100.00	3,601,100.00
210402	Тээвэр, шатахуун	23,037,200.00	23,023,330.00	23,023,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,969,700.00	2,713,000.00	2,713,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,235,800.00	6,235,800.00	6,235,800.00
210604	Урсгал засвар	6,235,800.00	6,235,800.00	6,235,800.00
2107	Томилолт, зочны зардал	6,685,700.00	6,685,700.00	6,685,700.00
210701	Гадаад албан томилолт	0	0	0
210702	Дотоод албан томилолт	6,685,700.00	6,685,700.00	6,685,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,135,700.00	6,854,241.00	6,854,241.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,447,700.00	6,447,000.00	6,447,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	0	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	81,675.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	50,574.00	50,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	0	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	200,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	138,300.00	74,992.00	74,992.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	0	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,018,400.00	43,159,980.00	43,159,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,715,000.00	42,856,580.00	42,856,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,611,600.00	46,611,600.00	46,611,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,611,600.00	46,611,600.00	46,611,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,611,600.00	46,611,600.00	46,611,600.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	554,589,800.00	534,894,443.35	534,894,443.35
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	534,519,443.35
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	534,519,443.35
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	505,193,100.00	534,519,443.35	0
320001	Орон нутгийн төсвөөс	505,193,100.00	534,519,443.35	0

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	49,396,700.00	375,000.00	375,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	375,000.00	375,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	49,396,700.00	0	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0
610001	Төсвийн байгууллага	1	1	0
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20	20	0
620001	Удирдах ажилтан	8	8	0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0
620004	Гэрээт ажилтан	0	0	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,525,105.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,525,105.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,525,105.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,703,187.00
210401	Бичиг хэрэг	95,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,588,187.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00
2107	Томилолт, зочны зардал	720,600.00
210702	Дотоод албан томилолт	720,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	307,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	307,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,793,918.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,793,918.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,525,105.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,525,105.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	40,525,105.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Яруу сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэн орон нутагтаа их бүтээн байгуулалт хөгжил дэвшилд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд “Цаг баримтлах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэн ажиллах” гэсэн гол зорилтод үндэслэн 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт, 52 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн ажилласан байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн биелэлт 78.1 хувьтай үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Яруу сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.799.0 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	12.6	-	(12.6)
Бараа материал	14,088.7	8,734.5	(5,354.2)
Үндсэн хөрөнгө	395,517.0	405,682.8	10,165.8
Нийт хөрөнгө	409,618.3	414,417.3	4,799.0
Өр төлбөр	-	0.1	0.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	409,618.3	414,417.2	4,798.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	409,618.3	414,417.3	4,799.0

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийдсэн худаг, гудамж болон хадлангийн талбайн хайс зэргийг орлогод авсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 459,657.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 49,396.7 мянган төгрөгөөр бууруулж, нийт 410,260.6 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 45,535.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө гэсэн 6 үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 505,193.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 534,823.7 мянган төгрөгийн санхүүжилт, олгож, гүйцэтгэл 534,419.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 0.78 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	353,113.2	362,647.9	-9,534.7	102.7
2	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	87,158.5	86,158.5	1,000.0	98.9
3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	1,200.0	0.0	100.0
4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	46,611.6	46,611.6	0.0	100.0
5	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	13,197.4	1,802.6	88.0
6	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	24,715.0	24,704.0	11.0	100.0
		Дүн	527,798.3	534,519.4	-6,721.1	101.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 40,525.1 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 20,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас 10,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл 5,000.0 мянган төгрөг, түрээс болон бусад орлогын 5,500.0 мянган төгрөг бүрдсэн байна. Үүнийг хамтарсан багийн зардал, хүүхдийн тоглоом, адуучин соёлын өв наадмын зардал, шатахуун зэрэгт зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Цэцэрлэгийн хүүхдийн тоглоом	20,000.0	20,000.0
		ДҮН	20,000.0	20,000.0

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 3/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 628,198.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,422.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 6,124.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 41 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс морин уралдааны телевизийн бичлэг хийлгэн зориулалт бус, үр ашиггүй зардал гаргасан 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулаагүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.old.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг анхан шатны баримт, мөнгөн гүйлгээний журналтай тулган шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тухай бүр оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Яруу сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 469,130.8 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт зөвлөмж, 40,720.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,566.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг тус тус 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,566.5	3	1,566.5	100
Албан шаардлага	1	40,720.8	1	40,720.8	100
Зөвлөмж	2	12,668.7	2	12,668.7	100
Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж	1	456,462.1	1	456,462.1	100
Нийт дүн	7	511,418.1	7	511,418.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 56,695.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 56,695.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Худалдан авсан биет бус хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй 4,500.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй 33,918.0 мянган төгрөг, бараа материалыг орлого дансанд бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан 18,277.0 мянган төгрөгийн алдаа гаргасан байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, ангилал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 5,402.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,402.1 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс морин уралдааны телевизийн бичлэг хийлгэн зориулалт бус, үр ашиггүй зардал гаргасан 1,000.0 мянган төгрөгийн зөрчил байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 2,402.1 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан нь юунд хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлон төлөвлөгөө, төсөв гаргаагүй шийдвэрлэсэн, 2,000.0 мянган төгрөгийн мотоцикл, эмчийн байрны засварт гаргасан байгууллага, хувь хүний хүсэлтийг шийдвэрлэсэн ч хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг ирүүлээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.3-д "нөөц хөрөнгийг зарцуулах үндэслэл, шаардлага, үр дүнг шийдвэрийн төслийн танилцуулгад тодорхой дурдсан байх", 6.1-д "Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс гарах зардлын хэрэгцээ, шаардлагыг тодорхой болгон, уг ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтнаас хөрөнгийн зарцуулалтын тайланг тогтоосон хугацаанд авч байх;

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газрыг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, УСНББОУС 31 Биет бус хөрөнгө АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын нэгдсэн системд бүртгэлтэй газруудыг данс бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/													
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан	Тоо	Дүн	Залруулаагүй	Тоо	Дүн	Зөвлөмж	
Худалдан авсан биет бус хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	4,500.0	1	4,500.0					1	4,500.0				
Үндсэн хөрөнгийг зөв ангилж бүртгээгүй	1	33,918.0			1	33,918.0			1	33,918.0				
Бараа материалыг орлого дансанд бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан	1	18,277.0			1	18,277.0			1	18,277.0				
Дүн	3	56,695.0	1	4,500.0	2	52,195.0	3	56,695.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 2,402.1 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан нь юунд хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлон төлөвлөгөө, төсөв гаргаагүй шийдвэрлэсэн, 2,000.0 мянган төгрөгийн мотоцикл, эмчийн байрны засварт гаргасан байгууллага, хувь хүний хүсэлтийг шийдвэрлэсэн ч хариуцан гүйцэтгэж	1	5,402.1	1	1,000.0			1	4,402.1				

